

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /биелээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээг хангахуйц, чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.								
Зорилт 1. Оношилгоо, эмчилгээ, сувिलाхуйн тусламж, үйлчилгээг орчин үеийн нотолгоонд суурилсан анагаах ухааны хөгжлийн түвшинд үзүүлэх								
1.1	Тархины нээлттэй мэс заслын тоог нэмэгдүүлнэ.		Шинээр хийсэн амжилттай тархины нээлттэй мэс заслын тоо	2021 онд тархины хавдрын мэс заслыг 3 удаа, тархины артерийн цүлхэнгийн мэс заслыг 3 удаа хийсэн байна.	Тархины хавдрын мэс засал, тархины артерийн цүлхэнгийн мэс заслыг тус тус 20-с доошгүй удаа хийсэн байна.	I-IV улирал	2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн хооронд мэдрэлийн мэс заслын тасагт тархины хавдрын болон цус харвалтын мэс засал нийт 30 хагалгаа хийж гүйцэтгэсэн байна.	100
1.2	Нурууны дуран болон бага хөнөөлт (minimal invasive) мэс заслыг эмчилгээнд нэвтрүүлж нутагшуулна.		Шинээр хийсэн амжилттай нурууны дуран болон бага хөнөөлт мэс заслын тоо	2021 онд нурууны дуран болон бага хөнөөлт мэс заслыг туршилтаар 3 удаа хийсэн байна.	Мэдрэлийн нурууны дуран болон бага хөнөөлт мэс засал хийж эмчилгээ, үйлчилгээнд нутагшуулсан байна.	I-IV улирал	2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн хооронд мэдрэлийн мэс заслын тасагт нийт 310 өвчтөн хэвтэн эмчлүүлснээс нурууны дуран болон хөнөөлт бага мэс засал 155 тохиолдолд хийж гүйцэтгэсэн байна.	100
1.3	Үений дурангийн мэс заслын тоо, нэр төрлийг нэмэгдүүлнэ.		Шинэ технологиор амжилттай хийсэн мэс заслын тоо	2021 онд өвдөгний үений дурангийн мэс заслыг 16 удаа, мөрний үений дурангийн мэс заслыг 1 удаа хийсэн.	Дурангийн мэс заслыг 50-с доошгүй удаа хийсэн байна.	I-IV улирал	2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд гэмтэл согог, ортопедийн тасагт 441 өвчтөн хэвтэн эмчлүүлснээс 402 тохиолдолд хагалгаа хийж гүйцэтгэсэн байна. Хагалгааны идэвх 91.2% бөгөөд 2022 онд үений дурангийн хагалгаа 23 тохиолдолд хийж гүйцэтгэсэн байна.	100
1.4	Ходоодны дурангийн ажилбарын төрлийг нэмэгдүүлж, дурангийн шинжилгээнд шинэ технологи нэвтрүүлнэ.		Шинэ технологиор амжилттай хийсэн ажилбарын тоо, шинжилгээний тоо	Одоогоор хийгдээгүй	Дурангийн ажилбарыг 2-оос доошгүй төрлөөр нэмэгдүүлж, улаан /гуурсан хоолой, ходоод, дээд/бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээг хийж эхэлсэн байна.	I-IV улирал	Дурангийн ажилбарыг: -Нарийн гэдэсний тэжээлийн энгийн болон 3 замтай гуурсыг нийт 12 тохиолдолд тависан. -ЦЕС-ийн том чулууг буталсан тохиолдол нийт 8 хийгдсэн. -Бүдүүн гэдэсний хавдрын бөглөрөлд хагалгааны өмнө төмөр стент тавьж бөглөрлийг арилгасан. -Ажилбарын тоо нийт дурангийн тооны 1/3 эзэлдэг.	100
1.5	Хэвлийн дурангийн мэс заслын нэр төрөл, нийт хагалгаан дахь эзлэх хувийг нэмэгдүүлнэ.		Шинэ технологиор амжилттай хийсэн мэс заслын тоо	2021 онд 40 нэр төрлийн дурангийн мэс заслыг 1560 тохиолдолд хийсэн.	Хэвлийн дурангийн мэс заслын нэр төрлийг 2-оор нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	Нийт хэвтэн эмчлүүлэх -3916 нийт мэс засал - 3435 дурангийн аргаар хийсэн мэс засал- 2061/65% Дурангийн мэс заслын нэр төрөл -57 Дурангийн элэг , нойр булчирхайн тайрах мэс засал-14 дурангийн аргаар ходоод тайрах мэс засал-10 Дурангийн аргаар ивэрхийн мэс засал-86 дурангийн аргаар гэдэс тайрах мэс засал-19 дурангийн мухар олгойн мэс засал-317 дурангийн аргаар уушгины мэс засал-13 дурангийн аргаар үнхэлцэг хальс нээх мэс засал -2 хэвлийн арын зайгаар дурангийн аргаар нойр булчирхайн үхэжсэн эд авах -4 Хөлсний булчирхайн хөлс ялгаралтыг багасгах Symphactomy VATS мэс засал хийсэн.	100

1.6	Бүдүүн шулуун гэдэсний мэс засалд шинэ арга технологийг нэвтрүүлнэ.		Шинээр нэвтрүүлсэн арга технологийн тоо	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслыг 26 төрлөөр хийж байна.	Бүдүүн шулуун гэдэсний мэс засалд нэг шинэ арга технологи нэвтрүүлж эхэлсэн байна.	I-IV улирал	1. бүдүүн гэдэсний хавдрын үед ULTRA LOW ANTERIOR RESECTION+ TME т 2. Бүдүүн гэдэсний хавдрын үед Laparoscopic transverse colectomy, intracorporeal anastomosis 3. Нарийн гэдэсний хавдрын үед Laparoscopic small bowel resection, intracorporeal anastomosis тус тус шинэ технологи нэвтрүүлсэн.	100
1.7	АВI мэс засал хийнэ. /Огт сонсголгүй хүнд АВI суулгах/		Шинэ технологoор амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор хийгдээгүй.	АВI Мэс засал хийж эхэлсэн байна.	I-IV улирал	Inter operation MRI шаардлагтай. Мэдрэлийн мэс засалч нар бэлтгэх.	100
1.8	Өнчин тархины хавдрын мэс заслыг /Суурийн хөндийгөөс дурангаар авах/ Мэдрэлийн мэс заслын тасагтай хамтран хийнэ.		Шинэ технологoор амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор хийгдээгүй.	Өнчин тархины хавдрын мэс заслыг хийж эхэлсэн байна.	I-IV улирал	Мэдрэлийн мэс заслын тасгийн тохиолдол хамтран хийх. Өвчтөнийг мэдрэлийн мэс засал оношилж бэлтгэнэ.	100
1.9	Гадна чихийг имплантаар нөхөн сэргээнэ.		Шинэ технологoор амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор хийгдээгүй.	Гадна чихийг имплантаар нөхөн сэргээх мэс засал хийж эхэлсэн байна.	I-IV улирал	1 тохиолдол хийгдсэн. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй. Протезийн өртгөөс шалтгаалж дахин өөр тохиолдол хийгдээгүй.	60
1.1	Ортогнатик мэс засал хийнэ.		Шинэ технологoор амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор хийгдээгүй.	Ортогнатик мэс засал хийж эхэлсэн байна.	I-IV улирал	Тохиолдлын тоо цөөн тул хийгдээгүй.	50
1.11	Эмэгтэйчүүдийн мэс засалд бичил зүслэгт мэс заслыг нэвтрүүлнэ.		Шинэ технологoор амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор хийгдээгүй.	2 зүслэгт дурангийн мэс заслын аргаар 10 өвчтөнд умайг авах мэс засал хийсэн байна.	I-IV улирал	2 зүслэгт дурангийн мэс заслын аргаар 10 өвчтөнд умайг авах мэс хийгдэх байснаас 2022 оны байдлаар 2 удаа хийж гүйцэтгэсэн байна. /хүйсний порт өртөг өндөр өртөгтийн санхүүжилт бага тул хийгдэх тоо бага байна /	60
1.12	Эмэгтэйчүүдийн хорт хавдрын мэс заслыг нэвтрүүлнэ.		Шинэ технологoор амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор хийгдээгүй.	Эмэгтэйчүүдийн хорт хавдрын мэс заслыг хийдэг болсон байна.	I-IV улирал	Умайн лейомиосаркома оноштой 2 өвчтөн, умайн хүзүүний эрт үеийн хавдартай 2 өвчтөнд дурангаар болон нээлттэй аргаар мэс засал хийгдсэн. лейомиосаркоматай 2 өвчтөн хагалгааны дараах хими, туяа эмчилгээнд орж байна. /1өвчтөн гадаадад эмчлүүлж байна/	100
1.13	Элэг цөс нойр булчирхайн мэс заслын чиглэлээр шинэ арга технологи нэвтрүүлнэ.		Шинээр нэвтрүүлсэн арга технологийн тоо	2021 онд 3 арга технологи нэвтрүүлсэн.	Элэг цөс нойр булчирхайн мэс заслын чиглэлээр 1-3 шинэ арга технологи нэвтрүүлж эхэлсэн байна	I-IV улирал	Элэг цөс нойр булчирхайн мэс заслын чиглэлээр – Дурангийн аргаар хэвлийн арын зайн нойр булчирхайн үхэжсэн эд авах мэс засал 4 тохиолдол хийгдсэн байна.	100

1.14	Эндоцигрий тодосгогч бодисыг хавдрын мэс засалд нэвтрүүлнэ.		Эндоцигрийн тодосгогч бодис ашиглан мэс засал хийгдсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Эндоцигрий тодосгогч бодисыг хавдрын мэс засалд нэвтрүүлж эхэлсэн байна.	I-IV улирал	2021 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 11дүгээр сарын байдлаар Ерөнхий мэс заслын тасагт нийт 315 хорт хавдрын мэс засал орсон байна. Үүнд: C22 буюу элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 95 тохиолдол C25 буюу элэгний гаднах цөсний суваг, нойр булчирхайн өмөн 17 тохиолдол C16 буюу ходоодны өмөн 51 тохиолдол C18,19,20,21 буюу бүдүүн, шулуун гэдэс, хошногоны өмөн 41 тохиолдол C50 буюу хөхний өмөн болон бусад 24 тохиолдлууд, D оношоор буюу бусад хоргүй хавдрын 87 тохиолдолд мэс засал хийж гүйцэтгэсэн байна.	100
1.15	Эрүү нүүрний мэс заслын үзлэгийн кабинет нээнэ.		Үзлэг, оношилгоо шинжилгээ хийсэн хүний тоо	Кабинет байхгүй	Эрүү нүүрний мэс заслын үзлэгийн кабинет нээж үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	I-IV улирал	2022 оны 8 сараас Эрүү нүүрний мэс заслын үзлэгийн кабинет нээж үйл ажиллагаа эхэлсэн. Амбулаторын эрүү нүүрний мэс ажилбар сувилагчийн хүрэлцээгүй тул чих хамар хоолойн кабинет-д хийгддэг. 2022 онд Эрүү нүүрний мэс заслын үзлэг нийт 700 өвчтөнд хийгдсэн байна. гүйцэтгэлийн хувь 100%	100
1.16	Амбулаторийн тусламж, үйлчилгээнд чих хамар хоолой, сонсгол судлал, хэл заслын кабинетийг шинээр байгуулна.		Үзлэг, оношилгоо шинжилгээ хийсэн хүний тоо	Кабинет байхгүй.	Амбулаторийн тусламж, үйлчилгээнд чих хамар хоолой, сонсгол судлал, хэл заслын кабинетийг шинээр байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	I-IV улирал	ABR ASSR OAE шинжилгээний аппаратны худалдан авалт хийгдээгүй тул үйл ажиллагаа тогтмол болоогүй байна.	0
1.17	Зүрхний мэс заслын тасаг шинээр байгуулна.		Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	Тусдаа тасаг байхгүй	Зүрхний мэс заслын тасаг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	III- IV улирал	2022 оны 12 дугаар сард 2023 онд ажиллах шинэ бүтэц Эрүүл мэндийн яамд хянагдаж байна. Хяналтын үйл ажиллагаа дуусмагц зүрхний мэс заслын тасаг шинээр байгуулагдах ажил шийдэгдэнэ.	0
1.18	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн нэр төрлийг нэмэгдүүлж, хагалгааны нэгдсэн тасагтай болсон байна.		Мэс заслын цагийн менежмент, Хагалгааны өрөөнүүдийн ашиглалтын үзүүлэлт	Нэгдсэн тасаг байхгүй.	Хагалгааны нэгдсэн тасгийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	I-IV улирал	Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг байгуулах бэлтгэл хийгдэж байна, бүтэц үйл ажиллагааны хувьд орон тоо батлагдаагүй байна. 2022 онд нийт 6826 мэдээгүйжүүлэгтэй мэс засал, ажилбар орсоноос Ерөнхий мэдээгүйжүүлэг - 4366, нугасны мэдээгүйжүүлэг - 1357, Бүсчилсэн мэдээгүйжүүлэг- 93 амбулаторын мэдээгүйжүүлэг, тайвшруулалт 1010 орсон байна.	100
1.19	Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ.		Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ байхгүй.	Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тасгийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт олгогдох боломжгүй болсон тул хэвтүүлэн эмчлэх тасгийн үйл ажиллагааг нээх боломжгүй болсон.	0
1.2	Тусламж, үйлчилгээнд цөмийн йод-131 эмчилгээг нэвтрүүлнэ.	ЭМД-ын сар	Цөмийн йод 131 эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Эмчилгээнд нэвтрээгүй.	Олон улсын стандартын нөхцлийг хангаж, цацраг идэвхт йод 131 эмийн эмчилгээг нэвтрүүлж эхэлсэн байна.	I-IV улирал	Хэвтэн эмчлүүлэх тасагт байрлах 3 өрөөнд цацрагийн аулгүй байдлын холбогдох стандарт зааврын дагуу орчны хяналтын детектор байрлуулсан. Йод-131 худалдан авах тендер зарласан боловч ханган нийлүүлэх компани орж ирээгүй тул эмчилгээ эхлээгүй.	0

1.21	Цөмийн оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээнд ФДГ тархины эмгэгийн ПЭТ/КТ оношилгоог нэвтрүүлнэ.	ЭМД-ын са	ФДГ тархины эмгэгийн ПЭТ/КТ оношилгоонд хамрагдсан хүний тоо	ФДГ тархины эмгэгийн ПЭТ/КТ оношилгоо эмнэлзүйд нэвтрээгүй байна.	ФДГ тархины эмгэгийн ПЭТ/КТ оношилгоог эмнэлзүйд нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Тархины эмгэгийн ФДГ ПЭТ/КТ оношилгонд техник хангамж болон чанарын баталгаажилт хангахын тулд: 1. КОFIN төслийн хүрээнд 10000\$ үнэ бүхий өндөр хүчин чадалтай компьютер болон хиймэл оюунд суурилсан програм хангамж 2. ОУАЭА-н төслийн хүрээнд хүсэлт гарган РЕТ/СТ чанарын баталгаажилт хангах 3D тархины фантом авсан. 3. Workstation худалдан авах 3 удаагийн тендер зарласан боловч ханган нийлүүлэх компани орж ирээгүй	0
1.22	Нүдний лазерын эмчилгээг нэвтрүүлнэ.		Хараа хамгаалах лазер мэс ажилбарын тоо	Одоогоор хийгдээгүй.	Эрчимт эмчилгээний тасгийн гемодиализ эмчилгээнд 50 -с доошгүй үйлчлүүлэгч харуулсан байна.	I-IV улирал	тоног төхөөрөмжийн болон дагалдах хэрэгслийн захиалга хийгдээгүй байгаа тул мэс ажилбар хийгдэж эхлээгүй байна.	0
1.23	Эрчимт эмчилгээний тасагт гемодиализтай болно.		Гемодиализэд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Одоогоор эрчимт эмчилгээний тасагт гемодиализ байхгүй.	Сувилахуйн стандарт ажиллагааны 17 ур чадварын зааврыг шинэчлэн баталж, мөрдөж ажилласан байна.	I-IV улирал	Эрчимт эмчилгээний тасагт гемодиализын аппарат суурилдаагүй, 1 эмч гемодиализын мэргэжил олгох курсэд суралцаж төгссөн. Аппарат суурилуулахыг хүлээж байна. Эрчимт эмчилгээний тасгийн 2 сувилагч гемодиализын төрөлжсөн мэргэшил олгох сургалтанд сууж төгссөн.	100
1.24	Сувилахуйн стандарт ажиллагааны заавар боловсруулна.	ЭМД санхүү	Шинээр батлагдсан сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн заавал сурах 17 ур чадварын стандартын заавар	Сувилахуйн стандарт ажиллагааны заавар батлаагүй.	ОУ-ын сувилагчийн өдрийг тохиолдуулан арга хэмжээ зохион байгуулж, төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд, 2022 оныг "Эрүүл мэндийн салбарын чанар, аюулгүй байдлын жил" болгон зарлантай холбоотой анагаах ухааны чиглэлээрх түгээмэл үйлдлийн стандартыг шинэчлэн, шинээр боловсруулах ажлын хэсгийг ЭМС-ын А/74 тоот тушаалаар баталсан бөгөөд тус эмнэлгээс 7 сувилагч төрөлжсөн сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. УХТЭ-ээс шинэчилэн боловсруулсан сувилахуйн стандарт ажиллагааны 17 ур чадварын заавар дээр үндэслэн нийт 36 сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартыг боловсруулж, санал хүргүүлсэн.	100
1.25	Сувилагч мэргэжилтний үнэ цэнэ, мэргэжлийн үйл ажиллагааг сурталчилах өдөрлөг зохион байгуулна		Өдөрлөгийн тайлан	одоогоор хийгдээгүй.	Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын түвшинг тогтоож, чанарын үзүүлэлтүүдийг хангаж ажилласан байна.	I-IV улирал	2022 оныг Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан сувилагч мэргэжлийн үнэ цэнэ, бие даасан байдал, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ҮОЭТ-ын 1 давхарт харвалтын дараах сувилахуй, дотрын өвчний сувилахуй, мэс заслын сувилахуй, хүүхдийн сувилахуй, сэргээн засахын сувилахуй, урьдчилан сэргийлэх сувилахуй, яаралтай тусламжийн үеийн сувилахуй тусламж үйлчилгээ зэрэг 7 чиглэлээр сувилагч мэргэжлийг сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан. Өдөрлөг арга хэмжээнд гаднаас тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч нарт зориулсан хэрэгсэл худалдаалдаг "Асаргаа сувилгааны хэрэгсэл" төрийн бус байгууллага оролцож хэрэгсэл бүрийн танилцуулга хийсэн.	100

1.26	Сувилахуйн чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулна.		Батлагдсан чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь	одоогоор хийгдээгүй.	2022 онд эрдэм шинжилгээний бүтээлийг 5-10%-иар нэмэгдсэн байна.	I-IV улирал	Сувилахуйн чанарын 2 шалгуур үзүүлэлтээр Эрчимт эмчилгээний тасаг, Харвалтын нэгж хэсэгт сүүлийн хагас жилд хяналт хийж ажиллаж байна. Эрчимт эмчилгээний тасагт 2022 оны 7 сарын 1 өдрөөс 11 сарын 30 байдлаар нийт 52 хүнд холголт кооролттой гэж бүртгэгдсэн ба үүний буюу 16 /30% нь тасагт ирснээс хойш холголт кооролт үүссэн ба үлдсэн 36 /69% нь ирэхдээ арьсны бүрэн бүтэн байтал алдагдсан ирсэн байна. Харвалтын нэгжид 107 хүнд Брайдений үнэлгээ хийснээс гаднаас холголт кооролттой ирсэн 2/1,8% хүнийг асаргаа сувилгаа хийж кооролтыг бүрэн эмчилсэн. Тасагт ирснээс хойш кооролт үүссэн хүн байхгүй.	100
1.27	Эмч мэргэжилтнүүд нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлд судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх, сургалтыг тогтмол хийнэ.		Шинээр хийсэн эрдэм шинжилгээний ажлын тоо	2021 онд 43 эрдэм шинжилгээний бүтээл туурвисан.	Мэдрэлийн ангиографын аппаратыг эмчилгээ үйлчилгээнд бүрэн ашиглаж, оношилгооны тоог нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	2022 онд эрдэм шинжилгээний бүтээлийг 5-10%-иар нэмэгдсэн. -Судалгааны 5 өгүүллийг гадаадын хэвлэлд нийтэлсэн, 4 судалгааны илтгэлийг гадаадын хуралд хэлэлцүүлсэн. -АШУУИС-ийн 80 жилийн ойд зориулсан ЭШХ-д УХТЭ-ээс 3 эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн. -Резидент эмч нарын эрдэм шинжилгээний хуралд эрдэм шинжилгээний 12 илтгэл хэлэлцүүлсэн. -Сувилахуйн ЭШХ-д 15 судалгааны илтгэл хэлэлцүүлсэн. - УХТЭ-ийн "Эрдмийн чуулган-44" эрдэм шинжилгээний хурал "Оновчтой менежмент- чанартай тусламж, үйлчилгээ" сэдвийн дор 10-р сарын 29-ний өдөр зохион байгуулсан бөгөөд 133 хураангуйг нэтгэж хянаж, бүтээл болгож хэвлэсэн. Тус ЭШХ нь 4 хэсгээр хуралдаж 37 илтгэлийг хэлэлцэж шилдэг илтгэлүүдийг шалгаруулсан. Мэдээллийн УХТЭ-ийн пэйж хуудаст нийтэлсэн.	100
1.28	Мэдрэлийн ангиографын аппарат ашиглалтад оруулна.		Оношлогоо эмчилгээ хийлгэсэн хүний тоо	2021- 8 сараас мэдрэлийн ангиографын оношлогоо эмчилгээг туршилтаар 50 хүнд үзүүлсэн.	Захын судас, хавдарын өвчин, мэдрэлийн өвчин эмгэгийн судсан дотуурхи оношлогоо эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр Улсын хоёрдугаар төв эмнэлэгт Bi-Plane Siemens Artis Zee маркын ангиографын аппаратыг бүрэн суурилуулж 2022оны 10 дугаар сарын 03ны өдөр албан ёсоор үйл ажиллагааг эхэлүүлэн одоогоор амжилттай ажиллаж байна. Үйл ажиллагаа эхэлсэнээс хойш нийт 32 эмчлүүлэгчид мэдрэлийн оношлогоо эмчилгээг хийж гүйцэтгэсэн байна.	100
1.29	Захын судас, хавдарын өвчин, мэдрэлийн өвчин эмгэгийн судсан дотуурхи оношилгоо эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.		Шинээр нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний нэр төрлийн тоо	2021 онд дүрсийн хяналттай эмчилгээ болон оношилгоог 354 хүнд хийсэн. Өндөр давтамжит радио долгионоор түлэх эмчилгээг 118 хүнд хийсэн.	Эмэгтэйчүүдийн PCR шинжилгээг хийж эхэлсэн байна.	I-IV улирал	Ангиографын тасаг нь 2022 онд хийгдэж буй ажилбарын нэр төрлийг нэмэгдүүлж амжилттай ажиллаж байна. Өвдөгний үений эмгэг судасжилтыг бөглөх эмчилгээг 2022 онд шинээр нэвтрүүлж одоогийн байдлаар 30 өвчтөнд амжилттай хийж гүйцэтгээд байна. Мөн доод мөчдийн өнгөц венийн өргөсөл /варикоз вен/-д өвчнийг түлэх эмчилгээг хийсээр байгаа.	100
1.3	Эмэгтэйчүүдийн PCR шинжилгээг хийнэ.		Хийгдсэн PCR шинжилгээний тоо	Одоогоор хийгдээгүй.	Ковидын дараах үеийн тусламж үйлчилгээг сайжруулан, ковидын шалтгаант эмгэгийн хүндрэлийг бууруулсан байна.	I-IV улирал	Эмэгтэйчүүдийн PCR шинжилгээг 27 Хүнд 94 үзүүлэлтээр хийхэд 14 хүнд эерэг хариу гарсан үр дүнтэй. үүсгэгчийн эсрэг үр дүнтэй эмчилгээг авч байгаа сайн талтай байна.	100

1.31	Ковидын дараах үеийн тусламж, үйлчилгээг сайжруулна.		Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2021 онд 150 хүн хэвтэн эмчлүүлсэн.	Ковидын дараах үеийн тусламж үйлчилгээг сайжруулан, ковидын шалтгаант эмгэгийн хүндрэлийг бууруулахаар халдварын хүндрэл илрүүлэх үзлэг эмчилгээг хийсэн байна.	I-IV улирал	Ковид-19 халдварийн дараах сэргээн засах эмчилгээний тасагт нийт 112 хүн, үүнээс 27 эрэгтэй, 85 эмэгтэй үйлчлүүлэгчид хамрагдсан үйлчлүүлэгчдэд уушигны үйл ажиллагааг, ачаалал даах чадварын үнэлгээг, ковидын халдварын дараах шинж тэмдэг, бие махбодийн ачаалал даах чадвар болон амьдралын идэвхийг үнэлэн үр дүнг тооцсон. Олон нийтэд зориулж өдөрлөг 1 удаа, КОВИД-19 халдварын дараах цувралаар 5 видео хичээл бэлтгэн цахим орчинд байршуулсан, эмч нарт зориулсан сургалтыг хот ба зүүн 5 аймгийн эмч нарт 6 удаа хийсэн байна.	100
Зорилт 2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, аюулгүй байдлыг эрхэмлэсэн тусламж, үйлчилгээг үзүүлж, нийгмийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх								
2.1	Үйлчлүүлэгч болон сувилахуйн мэргэжилтний сэтгэл ханамжийн судалгааг хийнэ.	/KOFIH төсл	Сэтгэл ханамжийн судалгааны зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Одоогоор хийгдээгүй.	Судалгааны зөвлөмжийн дагуу төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	KOFIH төслөөс сэтгэл ханамжийн судалгааны зөвлөмж ирсэн боловч манай эмнэлгийн сэтгэл ханамжийн судалгааны асуулттай ижил төстэй байсан болохоор Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 тоот тушаалын хоёрдугаар хавсралт "Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчээс авах сэтгэл ханамжийн үнэлгээний асуумж"-ийн 24,25,26 асуулгаас үнэлж дүгнэлт хийж байна.	90
2.2	Байгууллагын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг зохион байгуулж. Халдварт, халдварт бус өвчинтэй тэмцэх; Эрүүл насжилт, насны эрүүл мэнд хөтөлбөр арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2021 онд 1 стратеги, 6 үндэсний хөтөлбөр, хэрэгжилт 85%-тай байна.	Шинэ арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн байна.	I-IV улирал	Нийгмийн эрүүл мэндийн нийт хүн амд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болох Эрүүл мэндийн сайдын А/780 дугаар тушаал /Эрүүл, идэвхтэй амьдрал/, А/559 дүгээр тушаал /Эрүүл, чийрэг эр хүн/, А/760 дугаар тушаалыг /Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд/ хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл, идэвхтэй амьдрал арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 21 ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээний биелэлт 95 хувийн гүйцэтгэлтэй. Эрүүл, чийрэг эр хүн арга хэмжээ нь 2022 онд 3 зорилтын хүрээнд 9 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэн арга хэмжээний биелэлт 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ нь 2022 онд 2 зорилтын хүрээд 7 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Шинэ арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн. Монголын үндэсний телевизийн жаргалан нэвтрүүлэгт эмч Б.Жанибек "Гемодиализийн өвчтөнүүд ба ковидын халдвар" сэдвээр ярилцлага өгсөн. Монголын үндэсний телевизийн өглөө хөтөлбөрөөр эмч Г.Мөнжаргал "Цайрын хүний биед үзүүлэх нөлөө" сэдвээр мэдээлэл өгсөн. Дотоод шүүрлийн эмч нар "Чихрийн шижинтэй өвчтөний тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах" зорилгоор зүүн 4 аймаг, алслагдсан дүүргүүдийн эмнэлгийн Дотоод шүүрлийн нийт 25 эмчид /Багахангай, Багануур, Налайх/ KOFIH төслийн тусламжтай сургалтыг зохион байгуулсан. ХБЭСТ: Их эмч Н.Түвшинбаяр "Clinica" сувгаар 33 удаа зөвлөгөө өгсөн. Байгууллагынхаа сувилагч нарт "Цусаар дамжих элэгний В,Д халдварын оношлогоо, эмчилгээ" сэдвээр V/17-нд сургалт хийсэн.	100

2.3	Нийгмийн эрүүл мэндийн хүрээнд дэлхийн тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо, хандалтын тоо	2021 онд 9 дэлхийн тэмдэглэлт өдрийг зохион байгуулсан.	2022 онд Нийгмийн эрүүл мэндийн хүрээнд 11 тэмдэглэлт өдрийг зохион байгуулсан байна.	I-IV улирал	Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрийн хүрээнд 2022 онд 11 тэмдэглэлт өдрийн өдөрлөг сургалтын арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд: Зүрхээ хамгаалах дэлхийн өдөр, Эрчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал сургалт, Дэлхийн эрүүл мэндийн өдрийн өдөрлөг, Эрүүл мэндийнхээ төлөө -Алхангаа ярилцъяа өдөрлөг, Ахмад насны эрүүл мэндийг дэмжих сарын аян, Бөөрний эрүүл мэндийг хүн бүрт өдөрлөг, Чихрийн шижинтэй тэмцэх өдрийн өдөрлөг, Нянгийн эсрэг эмийн тэсвэржилтээс хэмтдаа сэргийлье өдөрлөг, Үйлчлүүлэгийн аюулгүй байдлын дэлхийн өдрийн өдөрлөг сургалт, Тархины харвалттай тэмцэх дэлхийн өдрийн өдрийн өдөрлөгийг тус тус зохион байгуулан ажилласан байна.	100
2.4	Байгууллагын нийтийн эзэмшлийн хүлээлгийн хэсгүүдээр эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор мэдээлэл, сурталчилгааны ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, хэвшүүлнэ.	-	Зохион байгуулсан мэдээлэл, сурталчилгааны тоо	2021 онд нийтийн эзэмшлийн хүлээлгийн кабинетийн хэсгүүдэд дэлгэцээр 29 сувиллагчийн постоор 3 зурагтаар 245 мэдээлэл, сурталчилгааг байршуулсан байна.	2022 онд 30ш дэлгэц, сувилагчийн постонд 2 зурагт шинээр байршуулан эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сурталчилгааг мэдээллэсэн байна.	I-IV улирал	2022 онд 30ш дэлгэц, сувилагчийн постонд 2 зурагт шинээр байршуулан эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сурталчилгааг танилцуулах зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг хүргэж эхэлсэн. Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэлийн цуврал контентийг 7 төрлийн сэдвийн хүрээнд явуулсан. Олон нийтийн цахим сайтаар шинэ технологи, эмчилгээгээ сурталчилсан байдал: Эмнэлгийн үйл ажиллагаа, шинэ эмчилгээ үйлчилгээг нийт 16 удаагийн цахим сайтаар таниулсан байна. Улсын хоёрдугаан төв эмнэлэг нь Хавдрын үед үзүүлдэг тусламж үйлчилгээг таниулах, иргэдэд хорт хавдраас урьчдлан сэргийлэх богино хэмжээний мэдээлэл бүхий 4 төрлийн видео шторкыг бэлтгэн эмнэлгийн цахим хуудсанд байршуулсан.	100
2.5	Иргэдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулах ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулна.	-	Эрт илрүүлгийн үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо	2021 онд 1226 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.	2022 онд 2000 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн үзлэг хийсэн байна.	I-IV улирал	2022 онд 428 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн үзлэг хийсэн байна. 2022 оны 03 сарын 15-ны Эрүүл Мэндийн Сайдын А/139 тоот тушаал "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам" дагуу УХТЭ нь БЗД-ийн 8,17-р хорооны иргэд болон үйлчлэх хүрээний хүн ардын дунд 2,215 хүнд эрт илрүүлэгт хамрагдсанаас 1 хүн ходоодны хорт хавдар оношлогдоод эмчилгээнд орсон. 2 иргэн батлах шинжилгээ хийлгээд явж байна. Мөн эндээс Хоол боловсруулах замын эмгэг тэргүүлэх байр суурь эзэлж байна. өмнөх оны урьдчилан сэргийлэх үзлэгийг давуулан биелүүлсэн байна.	100

2.6	Байгууллагын ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг идэвхижүүлж, эмч ажилчдын ёс зүйг дээшлүүлэн ажиллана.	Ёс зүйн зөрчлийн тоо	2021 онд 3 ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл бүртгэгдсэн байна.	Байгууллагын ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг идэвхижүүлж, ёс зүйн зөрчлийн тоог бууруулсан байна.	I-IV улирал	<p>- 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр тус эмнэлгийн хүсэлтээр "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр Монгол улсын их сургуулийн багш Г.Мягмар, "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тайлбар, мэдэгдэл гаргах, мэдэгдэл, тайлбар гаргахад анхаарах асуудлууд" сэдвээр Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар У.Номин-Эрдэнэ нар байгууллагын удирдлага, дунд шатны менежерүүд болох нийт 54 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад сургалт зохион байгууллаа.</p> <p>- "Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ" багц цагийн сургалтыг 2 удаа зохион байгуулж, эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нийт 365 хүнийг хамруулсан.</p> <p>- Содура консалтинг ХХК зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран нийт эмнэлгийн ажилтнуудад 4 удаа ёс зүй, харилцаа, хандлага, манлайлал гэсэн сэдвүүдээр сургалт явуулсан.</p> <p>- Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Содура консалтинг ХХК-ийн хамтран зохион байгуулсан ёс зүй, харилцаа хандлагын "Сургагч багшийн сургалт"-д эмнэлгийн СГХА-ны Д.Цэнджав, ЕМЗТ-ийн эмч М.Түвшинбаяр, МСТ-ийн Д.Мөнхжаргал, ЗССТ-ийн эмч Т.Байгалмаа, ЭЗХА-ны дарга О.Баяржаргал, БДШТ-ийн Э.Нарныгэрэл, СА-ны арга зүйч М.Оюунсайхан, Б.Оюунтуяа, ЗХНА-ны менежер Х.Болор, ЭМТҮЧАБА-ны менежер Б.Дулмаа, МЭЭТ-ийн сувилагч Б.Амарзаяа, РТ-ийн эмч Д.Энхжаргал нарын 12 эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.</p>	100
Зорилт 3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажилтаны сэтгэл ханамж тогтвортой байдлыг бэхжүүлэх							
3.1	Байгууллагын ажилтаны нийгмийн хамгааллыг сайжруулах төлөвлөгөө гаргана.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 85%-д хүрсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-аас доошгүй болгосон байна.	I-IV улирал	<p>-Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг 4 зорилт, 42 үйл ажиллагаатайгаар хэрэгжүүлдэг бөгөөд 1 дүгээр зорилтын хүрээнд 14 үйл ажиллагааны хэрэгжилт 90 хувь, 2 дугаар зорилтын хүрээнд 13 үйл ажиллагааны хэрэгжилт 90 хувь, 3 дугаар зорилтын хүрээнд 5 үйл ажиллагааны хэрэгжилт 90 хувь, 4 дүгээр зорилтын хүрээнд 7 үйл ажиллагааны хэрэгжилт 90 хувь, нийт хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувь байна.</p> <p>- Эрүүл мэндийн салбарын 2022 оны 4 дүгээр улирлын хамт(тариф)-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайланг 2022 оны 12 дугаар сарын 13-нд ЭМЯ-нд хүргүүлсэн.</p>	100

3.2	Эмнэлгийн гадаад харилцааг хөгжүүлж, тулгамдаж буй мэргэжлийн чиглэлээр өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, тоног төхөөрөмжийн инженерүүдийг тогтмол сургалтанд хамруулж, төсөл хөтөлбөрийг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллана.		Гадаад сургалтанд хамрагдсан ажилтаны тоо	2021 онд ҮОЭТ-ийн үйл ажиллагааны консолтинг төслийн хүрээнд 4 эмч, 3 инженер, мэргэжилтнийг сургасан.	2022 онд уг төслийн хүрээнд 7 албаны 20 мэргэжилтэн, удирдах ажилтанг 2 удаа сургалтанд хамруулсан байна.	I-IV улирал	2022 онд: -БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сангийн Dr.Lee Jong Wook-ын тэтгэлэгт сургалтад 3 эмч, цөмийн цацрагийн 2 мэргэжилтэн хамрагдсан. -БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сан, Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Канбуг Самсунг эмнэлгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу "Монгол Улсын Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны менежментийн 2-р шатны консалтинг" төслийн хүрээнд 7 албаны 21 мэргэжилтэн, удирдах ажилтанг 5 удаагийн урт болон богино хугацааны сургалтад хамрагдсан. - 2022 онд ЭМС-ын А\185 дугаар тушаалаар баталсан "Гадаадын өндөр хөгжилтэй оронд сургах тэргүүлэх чиглэл"-ийн дагуу ЗССТ-ын 2 эмч, 1 сувилагч "Зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал" чиглэлээр БНСУ-ын Йонсэй сэвэрэнс эмнэлэгт 10-р сарын 25-ны өдрөөс 2 сарын сургалтад суралцаж байна. Мөн ЕМЗТ-ийн 2 эмч "Нойр булчирхай болон нарийн гэдэс шилжүүлэн суулгах мэс засал" чиглэлээр БНСУ-ын Самсунг медиал төвд 12-р сарын 15-ны өдрөөс 2 сарын хугацаатай суралцах гэж байна.	100
3.3	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.		Шинээр батлагдсан ажилтны албан тушаалын тодорхойлолтын тоо	Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан журмаар албан тушаалын тодорхойлолт боловсруулагдаж байсан.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу ажилтны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан байна.	I-IV улирал	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу Дүрс оношилгооны төвийн дарга, Радиологийн тасаг, Цөмийн оношилгоо, эмчилгээний төв, Хоол шим тэжээлийн тасгийн, Нэгдсэн лабораторийн тасаг, Санхүү, бүртгэлийн албаны дарга, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга зэрэг нийт 73 албан тушаалтны Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/52, А/66, А/105, А/106, А/115, А/135 тушаал).	100
3.4	Эмч нарын мэргэжлийн өглөөний сургалт, сэтгүүлийн клубыг сард 2 удаа төлөвлөгөөний дагуу эх хэл болон гадаад хэл дээр /орос, англи/ өглөө 7:30-8:20 хооронд зохион байгуулж, хэвшүүлнэ.		Гадаад, дотоод хэл дээрх сургалтын тоо, сургалтанд хамрагдсан хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Төлөвлөгдсөн өглөөний сургалтууд бүрэн зохион байгуулагдсан байна.	I-IV улирал	Төлөвлөгдсөн өглөөний сургалтууд бүрэн зохион байгуулагдсан байна. Төв, эмнэлзүйн тасгууд 03 сараас эхлэн долоо хоног бүрийн пүрэв гариг бүрд "Өглөөний хэлэлцүүлэг" хийж байна. Одоогоор 25 удаа тасгууд өглөөний хэлэлцүүлэг хийсэн байна.	100
3.5	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг гүйцэтгэлээр нь үнэлэн олгоно.		Гүйцэтгэлийн үнэлгээний тайлан	2021 онд Засгийн газрын тогтоолын дагуу урамшууллыг олгосон.	Гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан урамшуулал олгосон байна.	I-IV улирал	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2022 оны I улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 180,327,968 төгрөг, 2022 оны II улиралд 509 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 191,285,364 төгрөг, 2022 оны III улиралд 506 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 165,355,960 төгрөг, олгогдсон (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/164, Б/249, А/104 тушаалууд)	100

3.6	Эмнэлгийн мэргэжилтний ур чадварын зэрэг, магистр, докторын зэргийг нэмэгдүүлж, цалин урамшуулалд нэмэгдлийг тооцон олгож байна		ЭМС-ын тушаалаар мэргэжлийн зэрэг олгосон тушаал, зэрэг авсан хүний тоо	2021 онд АУ-ны доктор 2, АУ-ны магистр 3 зэрэгтэй мэргэжилтэнд цалинд урамшуулал тооцож олгосон.	2022 онд нэмж АУ-ны доктор 2, АУ-ны магистр 3, мэргэжилтний зэргийг хамгаалуулан, тушаалаар нэмэгдэл олгуулна	I-IV улирал	2022 онд шинээр Анагаах ухааны доктор 2, Анагаах ухааны магистр 3. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/368 дугаар тушаалаар тус эмнэлгийн мэргэжилтний зэрэг ахиулсан болон шинээр зэрэг хамгаалсан мэргэжилтний нэрс батлагдсан. Үүнд: Зөвлөх эмч 1, Зөвлөх сувилагч 2, Тэргүүлэх эмч 6, Тэргүүлэх сувилагч 5, Ахлах эмч 2, Ахлах сувилагч 2 хамгаалсан бөгөөд эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 11, Зөвлөх эмч 12, Зөвлөх сувилагч 2, Тэргүүлэх эмч 38, Тэргүүлэх сувилагч-39, Ахлах эмч 29, Ахлах сувилагч 41, бусад мэргэжилтэн 4 ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, эмнэлгийн ерөнхий захирлын тушаалын дагуу нийт эмнэлгийн мэргэжилтэнд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон олгож байна (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/91 дүгээр тушаал)	100
3.7	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу эмнэлгийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулна.		Шинэчлэгдэн байгуулсан хөдөлмөрийн гэрээ	Эмнэлгийн бүх ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу эмнэлгийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулна.	I-IV улирал	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу "Хөдөлмөрийн дотоод журам" шинэчлэх, бэлтгэл ажлын хангах зорилгоор Эмнэлгийн үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/06, А/29 тушаалаар "Ажлын хэсэг" байгуулан ажилласан,	100
3.8	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмыг нийцүүлж шинэчлэн боловсруулна.		Шинээр батлагдсан эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журам	2021 онд Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлуулсан.	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмыг нийцүүлж шинэчлэн боловсруулсан байна.	I-IV улирал	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн "Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулан Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар батлан, хэрэгжүүлж эхэлсэн. Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу эмнэлгийн удирдах ажилтан, хэсэг, тасаг, албадын нийт 43 албан тушаалтантай "Хөдөлмөрийн гэрээ" шинээр болон шинэчлэн байгуулсан.	100
3.9	Харьяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүд дээр ажлын байрны сургалт, иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн үзлэг, тусламж, үйлчилгээ үзүүлнэ.		Сургалт; тусламж, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Харьяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүд дээр ажлын байрны сургалт, иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн үзлэг, тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.	I-IV улирал	хагас жилээс хойш: ангиографийн үндэсний багийн бүрэлдэхүүнд орж Хэнтий, Дорнод аймгийн эмнэлэг, БОЭТ-д ажилласан байна. Мөн Хэнтий аймагт хавдар, зүрх судас, дүрс оношилгоо, мэдрэлийн эмч нарын баг ажилласан. Багахангай дүүргийн нэгдсэн эмнэлэгт нүд, чих хамар хоолойн эмч нарын баг ажиллаж үзлэг, сургалт хийсэн.	100
3.1	Телемедицинийг ашиглалтад оруулж харьяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдтэй холбогдон сургалт, зөвлөгөө өгнө.		Зөвлөгөө, сургалтанд хамрагдсан хүний тоо	Телемедицин ашиглагдаагүй байгаа.	Телемедицинийг ашиглалтад оруулж харьяа аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдтэй холбогдон сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	I-IV улирал	21 аймгийн нэгдсэн эмнэлэг 5 бүсийн оношлогоо эмчилгээний төв, клиникийн төрөлжсөн нарийн мэргэжлийн 7 төвүүдэд эмнэлгийн телемедициний тоног төхөөрөмжүүдийг бүрэн ашиглалтад оруулж зөвлөгөө өгөх боломжоор хангасан. Өөрийн эмнэлгийн харьяа Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь Говьсүмбэр аймгуудын эрүүл мэндийн төвүүдэд очин тоног төхөөрөмжүүдийг хэрхэн холбох, холбогдон сургалт, зөвлөгөө өгөх зэргээр сургалт явуулан үйл ажиллагаанд оруулсан.	100

Зорилт 4. Байгууллагын дэд бүтэц, цахим мэдээлэлийн тогтолцоог сайжруулах

4.1	Сургалтын өрөөг тохижуулна.	Банкнуудын	Стандарт сургалтын өрөө	Засвар хийгдээгүй өрөө	Сургалтын өрөөг тохижуулж, сургалт зохион байгуулах таатай орчин бүрдүүлж ашиглалтад оруулаагүй байна. Сүүлийн хагас жилд хийгдсэн байна.	I-IV улирал	Сургалтын өрөөг тохижуулж, сургалт зохион байгуулах таатай орчин бүрдүүлэх зорилгоор төгсөлтийн өмнөх болон дараах сургалт зохион байгуулж буй зарим сувилахуйн сургууль, сургалтын байгууллагаас туршлага судлан, УХТЭ-ийн эмч сувилагч, эмнэлгийн ажилчдын хандиваар 1,850,000 төгрөгийн өртөг бүхий тохижилт хийгдсэн. -Сургалт, гадаад харилцааны алба нь урсгал засвар хийж, энэ онд улсын комисст хүлээлгэн өгсөн эмнэлгийн хойно байрладаг 2 давхар байшингийн 2-р давхарт байрлаж байна. Одоо сургалтын албанд дарга, арга зүйчийн ажлын өрөөнөөс гадна семинар, сургалтын 2 өрөө, номын сан, уншлагын танхимд сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. -ХБЭСТ, ЕМЗТ, МСТ, ЗССТ-уудад резидент эмч нарын 4 сургалтын өрөөнд урсгал засвар хийж, шинэ тавилга хэрэгсэл, ширээ сандал, сургалтын хэрэгсэлээр тохижуулж, шинээр зохион байгуулсан.	100
4.2	Эмч хөгжлийн төвийн барилгыг ашиглалтанд оруулна.		Баригдаж, улсын комисс хүлээн авсан барилга	2021 онд барилгын ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна.	2023 оны 3,4-р улиралд үйл ажиллагааг дуусгаж, барилгыг ашиглалтанд оруулсан байна.	I-IV улирал	Санхүүжилт нь ЭМЯ-с хамааралтай байгаа тул 2022 оны байдлаар төлөвлөгөөт ажил хийгдээгүй.2023 оны 3,4-р улиралд үйл ажиллагааг дуусгаж, барилгыг ашиглалтанд оруулна.	60
4.3	Эмч хөгжлийн төвд бүрэн тоноглогдсон сувилахуйн сургалтын өрөөг бий болгоно.	/КОФИН төсө	Шинээр байгуулагдан ашиглалтанд оруулсан сувилахуйн сургалтын өрөө	Эмч хөгжлийн төв ашиглалтанд ороогүй байна.	Сувилахуйн сургалтын өрөө ашиглалтад орж үйл ажиллагаа эхлээгүй байна. Сүүлийн хагас жилд ашиглалтад оруулсан байна.	I-IV улирал	Сувилахуйн сургалтын өрөө ашиглалтад орж үйл ажиллагаа эхлээгүй байна. 2023 оны төлөвлөгөөнд орсон байгаа.	0
4.4	50 ортой эмнэлгийн байрны засварын ажлыг эхлүүлнэ.		50 ортой эмнэлгийн барилгын засварын ажлын хувь	Одоогоор хийгдээгүй.	50 ортой эмнэлгийн байрны засварын ажлыг эхлүүлсэн байна.	I-IV улирал	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 ортой байрны их засварын ажил 3.4 тэрбум бүхий төсөвтэй зураг төслийг гаргаж Эрүүл мэндийн яамд хүргүүлсэн болно. 2023 онд хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор эмнэлгүүдэд урсгал засварын төсөв эцсийн байдлаар батлагдаагүй байна.	0
4.5	Эмгэг судлалын байрны засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.		Эмгэг судлалын байрны сангийн засвар, цэвэр усны шугам татах ажлын гүйцэтгэлийн хувь	Одоогоор хийгдээгүй.	Эмгэг судлалын байрны засварын ажлыг хийж дуусгасан байна.	I-IV улирал	2022 оны 8 дугаар сарын 5-ны өдөр "ПИӨРЛИ ТАУР"-тай 49,095,928 төгрөгний төсөвтэй сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулан эмгэг судлалын байрны сангийн засвар, цэвэр усны шугам татах ажлын гүйцэтгэлийн хувь 100 дууссан. Улсын комисс ажиллахыг хүлээж байгаа.	50
4.6	Эмнэлгийн эмнэлзүйн нэгдсэн Карте системийг хөгжүүлнэ.		Эмнэлгийн мэдээллийн систем нэвтэрсэн байдал	2021 онд цаг үетэй холбоотойгоор Карте системийн хөгжүүлэлтийн хэрэгжилт 85%-д хүрсэн.	Карте системийн хөгжүүлэлтийг 90%-аас доошгүй хувьд хүргэсэн байна.	I-IV улирал	Эмнэлзүйн нэгдсэн үйл ажиллагааны Карте системийн үйл ажиллагааг тогтмол шинэчлэн сайжруулж байна.ЭМС тушаал болон ЭМДҮЗ-ын тогтоолын дагуух өөрчлөлтүүдийг цаг хугацаанд нь тогтмол оруулан ажиллаж байна.2022 онд улс орон даяар эрт илрүүлэг эхлүүлсэнтэй холбогдуулан Эрт илрүүлгийн хэсгийг хэсгийг ажилд оруулсан.Мөн ЭМС болон эмнэлгийн дотоод үйл ажиллагаанд ашигладаг хэд хэдэн маягт шийдвэрүүдийг цахим хэлбэрт шилжүүлэн өвчтөний түүхийг бүрэн цахимжуулах зорилт тавин ажиллаж байна.	100
4.7	Эмнэлгийн хяналтын камерын системийг сайжруулах эмнэлгийн гадаад орчныг камержуулна		Шинээр суурилуулсан хяналтын камерын тоо	Гадаа камер байхгүй .	Эмнэлгийн хяналтын камерын систем, гадаад орчныг камержуулсан байна.	I-IV улирал	Эмнэлгийн хяналтын камерын системийг сайжруулах зорилгоор эмнэлгийн гадаад орчны камерын зураг төсөл болон санхүү тооцоог бүрэн гарган тооцоолсон.Төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас болоод хийгдээгүй.	0

4.8	Эмнэлгийн мэдээллийн системийг бүртгэл мэдээллийн нэгдсэн E-Mongolia системд холбоно.		E-Mongolia системд нэвтэрсэн байдал	Одоогоор хийгдээгүй.	E-Mongolia системд холбогдсон байна.	I-IV улирал	Амбулаторын эмчийн үзлэгийн цаг олголт болон эрт илрүүлгийн хариу олголтын хэсгийг E-Mongolia цахим мэдээллийн системтэй холбосон. E-Mongolia системээр хариу авах боломжоор хангагдсан.2022 онд E-Mongolia системээр амбулаторын 510 үйлчлүүлэгчийн үзлэгийн цаг захиалагдсан байна.	100
Зорилт 5. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах								
5.1	Эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлсэн шинэ технологитой холбоотой өртгийг тооцно.	-	Шинээр тооцсон тусламж, үйлчилгээний өртөг	Одоогоор хийгдээгүй.	Шинэ технологитой холбоотой өртөг тооцож Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.	I-IV улирал	19 нэр төрлийн шинжилгээ оношилгооны өртөг тооцон Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж төлбөрт тусламж үйлчилгээний жагсаалтанд оруулсан.	100
5.2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцооны бэлтгэл ажлыг хангаж хэрэгжүүлнэ.	-	Гүйцэтгэлийн санхүүжилт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоо нэвтэрсэн байна.	I-IV улирал	Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж,эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 482 оношийн хамаарлын бүлгийн хүрээнд сонгон шалгаруултанд орж 472 оношийн хамаарлын бүлгээр тэнцэн гэрээ хийн шалгуур хангаж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлэн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Мөн Монголдоо төдийгүй 100,000 хүн амд ховор тохиолдох хүүхдийн ясны болон цусны хавдар, өвдөнгий остеоартрит өвчний үеийн эмгэг судасжилтыг ангиографийн аргаар бөглөх эмчилгээг шинээр бүртгүүлэх тухайн оношийг эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 01, 12-р тогтоолд нэмүүлэх санал хүргүүлэн ажиллаж байна	100
5.3	Байгууллагын үйл ажиллагаатай уялдсан засаглалын тогтолцоог хагас бие даасан тогтолтоонд шилжүүлэх бэлэн байдлыг хангана.		Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдсан байна.	Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаагүй байна.	Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	I-IV улирал	Эрүүл мэндийн сайдын баталсан "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн эмнэлгийн хамт олны төлөөллийг нэр дэвшүүлэх хурлыг зохион байгуулах удирдамж"-ийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр "Улсын хоёрдугаар төв эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тус эмнэлгийн хамт олныг төлөөлөх 3 гишүүнийг нэр дэвшүүлэх хурлыг зохион байгуулж төлөөллийг сонгон хурлын тэмдэглэл, бусад холбогдох баримтуудын хамт эх хувийг журмын дагуу архивлан хадгалахад бэлэн болгож ЭМЯ-ны төлөөлөлд хүлээлгэн өгсөн.	0
5.4	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн төлөвлөлттэй уялдуулан байгууллагын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлнэ.		Шинэчлэн батласан стратеги төлөвлөгөө	2018-2021 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.	Байгууллагын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг батлуулсан байна.	I-IV улирал	"Содура" консалтинг компаниас авч буй зөвлөх үйлчилгээний хүрээнд эмнэлгийн 2022-2026 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан 2023 онд батлуулахаар ажиллаж байна. Төлөвлөгөөг эхний байдлаар Эрүүл мэндийн яамд танилцуулах шатандаа явж байна.	100

5.5	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн чиглэлээр байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад сургалт, сурталчилгаа тогтмол зохион байгуулан ажиллана.		Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	2021 онд байгууллагын нийт ажилчдад сургалт хийгдсэн.	2022 онд Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой сургалтын тоог нэмэгдүүлэн тогтмолжуулсан байна.	I-IV улирал	2022 оны 05 дугаар сард Азийн хөгжлийн банкны Төслийн хүрээнд "Эрүүл мэндийн салбарын шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн удирдлагын багийг чадавхижуулах" сургалтад эмнэлгийн нийт хэсэг, тасаг, албадын дарга нарыг хамруулсан. Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой сургалтуудыг танхимын 9 болон ажлын байран дээр тогтмол явуулж байна.	100
5.6	Авилгалтай тэмцэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.		Төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийн хувь	Авилгалтай тэмцэх төлөвлөгөө байхгүй.	Авилгалтай тэмцэх төлөвлөгөөг батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ" батлуулан хэрэгжүүлж, "УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ", зурган хавсралтын хамт 2022 оны 05 дугаар 19-ний өдөр, 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тус тус Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.	100
<p>Жич: ЭМЯ-ны 2022.01.10-ны өдрийн 3/88 дугаар албан бичгийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах бодлогын бичиг баримтуудад тусгагдсан өөрийн эмнэлгийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээнүүдийг</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (ЗГҮАХ: Засгийн газрын үйл - Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (МУТЖҮЧ:Монгол улсын таван жилийн үндсэн чиглэл). - Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө - Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд 2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (БДХСтратеги: Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөө) - ЭМСайдаас А/549 тушаал, ЭМСайдын 2022 оны 01, 02 дугаар албан даалгавруудаар тусгайлан нэмэлтээр үүрэг болгосон арга хэмжээнүүдийг багтаасан болно. 								
<p>2022 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 61 ажил төлөвлөсөн. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр төлөвлөсөн 36 ажил - 2021 онд хагас биелэлттэй 5 ажил - Тогтмол зохион байгуулдаг 12 ажил байгаа болно. 								

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

..... /Б. ЭРДЭНЭБУЛГАН /

2022.12.15